



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,  
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН ДАРГЫН  
ТУШААЛ

2025 оны 10 сарын 01 өдөр

Дугаар А/48

Улаанбаатар хот

Ажлын хэсэг байгуулах тухай

Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.2, 8.4 дэх хэсгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Монгол Улсын Төрийн өмчийн хороо /хуучин нэршлээр/ болон П.Гэндэнгийн нэрэмжит сангийн хооронд 2007 оны 474 тогтоолоор байгуулсан өмч шилжүүлэх, эзэмшүүлэх гэрээг дүгнэх, гэрээгээр хүлээлгэн өгсөн хөрөнгөд үзлэг шалгалт хийж дүгнэлт гаргах үүрэг бүхий ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй томилсугай.

Ахлагч:

Д.Нарангэрэл

Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын  
Төрийн өмчийн бүртгэл, ашиглалтын хэлтсийн дарга

Гишүүд:

В.Дарханбаатар

Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын  
Төрийн өмчийн удирдлага, төлөөллийн албаны дарга

Д.Батболд

Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын  
Төрийн өмчийн бүртгэл, ашиглалтын хэлтсийн  
ахлах мэргэжилтэн

Д.Цэрэнлхам

Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын  
Захиргаа, удирдлагын хэлтсийн мэргэжилтэн

Х.Нарангарав

Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын  
Хууль, эрх зүйн хэлтсийн мэргэжилтэн

Б.Баярцэцэг

Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын  
Хяналт, шалгалтын хэлтсийн мэргэжилтэн

Т.Батгэрэл

Барилгын хөгжлийн төвийн барилга байгууламжийн  
захиалагчийн хяналтын хэлтсийн ахлах инженер  
/зөвшилцсөнөөр/

Нарийн бичгийн дарга:

Л.Гэрэлмаа

Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын  
Төрийн өмчийн бүртгэл, ашиглалтын хэлтсийн  
мэргэжилтэн

2. Ажлын хэсгийн удирдамжийг хавсралтаар баталсугай.

3. Удирдамжийн дагуу үзлэг шалгалтыг 2025 оны 10 дугаар сарын 6-ны өдрөөс эхлэн ажлын 20 хоногт багтаан хийж гүйцэтгэн, тайланг танилцуулахыг Ажлын хэсэг (Д.Нарангэрэл)-т үүрэг болгосугай.

ДАРГА

Б.ЦЭНГЭЛ 132003261